



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/47/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Аудитор: Б.Цэвэлмаа Утас: 99026016	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 93

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07020050

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,210,537.54	107,361,332.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	1,426,283.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	1,426,283.00
31210	Төгрөг	0.00	1,426,283.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	8,783.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	1,417,500.00
33	АВЛАГА	5,385,000.00	73,517,500.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	500,000.00	0.00
33500	Бусад авлага	4,885,000.00	73,517,500.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	68,632,500.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,885,000.00	4,885,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,825,537.54	32,417,549.62
35100	Түүхий эд материал	7,521,096.93	18,363,854.61
35130	Эм боох материал	7,521,096.93	18,363,854.61
35400	Хангамжийн материал	18,304,440.61	14,053,695.01
35410	Бичиг хэргийн материал	92,000.00	186,000.00
35420	Аж ахуйн материал	6,181,425.45	5,541,567.45
35440	Түлш, шатах тослох материал	5,423,600.00	3,520,000.00
35450	Барилгын засварын материал	2,781,000.00	281,000.00
35460	Хүнсний материал	1,473,180.00	1,079,348.00
35470	Бусад хангамжийн материал	2,353,235.16	3,445,779.56
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	316,995,883.70	325,205,478.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	316,995,883.70	325,205,478.87
39200	Биет хөрөнгө	311,909,883.70	320,119,478.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	272,075,275.54	272,075,275.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,540,036.62	-16,436,800.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	72,722,000.00	74,516,871.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-41,761,834.52	-47,124,013.97
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	52,637,096.65	74,259,760.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,790,097.34	-49,782,087.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,365,156.06	9,465,156.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,890,176.06	-6,398,582.11
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,355,400.00	10,355,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-262,900.01	-811,500.05
39300	Биет бус хөрөнгө	5,086,000.00	5,086,000.00
39301	Програм хангамж	795,000.00	795,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-795,000.00	-795,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,086,000.00	5,086,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	348,206,421.24	432,566,811.49
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	500,000.00	18,402,101.08
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	500,000.00	18,402,101.08
41300	Өглөг	500,000.00	18,402,101.08
41360	Бусад өглөг	500,000.00	18,402,101.08
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	17,358,101.08
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	500,000.00	1,044,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	347,706,421.24	414,164,710.41
51	Засгийн газрын хувь оролцоо	347,706,421.24	414,164,710.41
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	68,800,039.61	68,800,039.61
51200	Хуримтлагдсан үр дүн	-37,087,384.25	29,370,904.92
51210	Өмнөх үеийн үр дүн	-50,442,394.14	-37,087,384.25
51220	Тайлант үеийн үр дүн	13,355,009.89	66,458,289.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	315,993,765.88	315,993,765.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	348,206,421.24	432,566,811.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	318,207,135.30	484,919,296.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,868,635.30	73,733,793.63
120	Нийтлэг татварын бус орлого	24,868,635.30	73,733,793.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,868,635.30	73,733,793.63
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	18,043,666.00	21,017,535.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,304,969.30	52,716,258.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	293,338,500.00	411,185,503.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	273,824,900.00	298,187,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	273,824,900.00	298,187,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,023,600.00	98,914,953.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	21,529,953.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,600.00	0.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	77,385,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	16,490,000.00	13,740,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,490,000.00	13,740,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	343,350.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	343,350.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	304,852,125.41	418,461,007.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,852,125.41	418,461,007.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,458,306.29	396,836,473.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,799,903.88	228,057,000.00
210101	Үндсэн цалин	125,999,903.88	128,126,000.00
210102	Нэмэгдэл	55,200,000.00	65,250,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,600,000.00	3,600,000.00
210104	Урамшуулал	11,000,000.00	16,781,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	14,300,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,322,193.00	29,335,089.00
210201	Тэтгэврийн даатгал	16,840,575.00	20,796,889.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,959,302.00	2,160,310.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,567,441.00	1,790,348.00
210204	Ажилгүйдлийн даатгал	359,536.00	422,222.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,595,339.00	4,165,320.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,923,000.00	12,395,466.00
210301	Гэрэл, цахилгаан	1,000,000.00	1,625,466.00
210302	Түлш, халаалт	8,923,000.00	10,770,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,077,187.18	25,748,464.00
210401	Бичиг хэрэг	1,213,846.00	1,149,025.00
210402	Тээвэр, шатахуун	16,497,160.00	19,459,866.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,089,073.00	4,619,573.00
210408	Бараа материал акталсны зардал	6,877,108.18	0.00
2105	Нормативт зардал	15,546,469.77	79,286,897.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,814,687.77	74,111,145.63
210502	Хоол, хүнс	2,801,782.00	5,175,752.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,930,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,518,500.00	4,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	1,518,500.00	2,000,000.00
2107	Томилот, зочны зардал	270,000.00	519,057.00

210702	Дотоод албан томилолт	270,000.00	519,057.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,628,578.00	1,293,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,813,538.00	347,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	450,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	199,940.00	102,860.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	399,100.00	393,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,372,474.46	15,701,139.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	824,500.00	393,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,547,974.46	15,307,939.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,393,819.12	21,624,534.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	21,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	21,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,500.00	24,534.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,500.00	24,534.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,788,319.12	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,788,319.12	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	13,355,009.89	66,458,289.17
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	13,355,009.89	66,458,289.17

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,800,039.61	315,993,765.88	-50,442,394.14	334,351,411.35
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,800,039.61	315,993,765.88	-50,442,394.14	334,351,411.35
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	13,355,009.89	13,355,009.89
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,800,039.61	315,993,765.88	-37,087,384.25	347,706,421.24
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	68,800,039.61	315,993,765.88	-37,087,384.25	347,706,421.24
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,800,039.61	315,993,765.88	-37,087,384.25	347,706,421.24
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	66,458,289.17	66,458,289.17

2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	68,800,039.61	315,993,765.88	29,370,904.92	414,164,710.41
---------------------------------------	---------------	----------------	---------------	----------------

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	293,838,500.00	343,053,003.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	500,000.00	500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	500,000.00	500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	500,000.00	500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	293,338,500.00	342,553,003.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	273,824,900.00	298,187,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	273,824,900.00	298,187,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,023,600.00	30,282,453.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	21,529,953.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		8,752,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	16,490,000.00	13,740,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,490,000.00	13,740,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	343,350.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	343,350.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	293,358,500.00	339,126,720.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	293,358,500.00	339,126,720.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	290,464,680.88	317,502,186.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,799,903.88	228,057,000.00
210101	Үндсэн цалин	125,999,903.88	128,126,000.00
210102	Нэмэгдэл	55,200,000.00	65,250,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,600,000.00	3,600,000.00
210104	Урамшуулал	11,000,000.00	16,781,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	14,300,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,322,193.00	29,335,089.00
210201	Тэтгэврийн даатгал	16,840,575.00	20,796,889.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,959,302.00	2,160,310.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,567,441.00	1,790,348.00
210204	Ажилгүйдлийн даатгал	359,536.00	422,222.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,595,339.00	4,165,320.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,435,000.00	11,715,466.00
210301	Гэрэл, цахилгаан	1,000,000.00	1,625,466.00
210302	Түлш, халаалт	9,435,000.00	10,090,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,060,706.00	19,698,378.00
210401	Бичиг хэрэг	1,299,946.00	1,010,025.00
210402	Тээвэр, шатахуун	17,720,760.00	16,074,738.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,640,000.00	2,093,615.00
2105	Нормативт зардал	13,266,900.00	23,698,636.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,300,000.00	19,354,216.00
210502	Хоол, хүнс	3,166,900.00	4,207,620.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	136,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,299,500.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	4,299,500.00	2,000,000.00

2107	Томилолт, зочны зардал	270,000.00	519,057.00
210702	Дотоод албан томилолт	270,000.00	519,057.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,386,978.00	1,293,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,571,038.00	347,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	450,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	199,940.00	102,860.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	400,000.00	393,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,623,500.00	1,185,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,623,500.00	1,185,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,893,819.12	21,624,534.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	21,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	21,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,500.00	24,534.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,500.00	24,534.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,288,319.12	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,288,319.12	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	480,000.00	3,926,283.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	480,000.00	2,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	480,000.00	2,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	480,000.00	2,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	480,000.00	2,500,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-480,000.00	-2,500,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	1,426,283.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,426,283.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	Цэвэр гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	323,443,800.0	312,737,233.00	10,706,567.00	97%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	323,443,800.0	312,737,233.0	10,706,567.0	97%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,843,800.0	312,137,233.00	10,706,567.0	97%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,276,000.0	223,276,000.00	-	100%
210101	Үндсэн цалин	128,126,000.0	128,126,000.00	-	100%
210102	Нэмэгдэл	65,250,000.0	65,250,000.00	-	100%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,600,000.0	3,600,000.00	-	100%
210104	Урамшуулал	12,000,000.0	12,000,000.00	-	100%
210105	Гэрээт ажлын хөлс	14,300,000.0	14,300,000.00	-	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,844,300.0	28,766,504.00	77,796.0	100%

210201	Тэтгэврийн даатгал	20,420,300.0	20,342,504.00	77,796.0	100%
210202	Тэтгэмжийн даатгал	2,124,500.0	2,124,500.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,761,700.0	1,761,700.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	417,700.0	417,700.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,120,100.0	4,120,100.00	-	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,740,000.0	11,715,466.00	24,534.0	100%
210301	Гэрэл, цахилгаан	1,650,000.0	1,625,466.00	24,534.0	99%
210302	Түлш, халаалт	10,090,000.0	10,090,000.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	22,233,600.0	18,898,067.00	3,335,533.0	85%
210401	Бичиг хэрэг	1,324,700.0	960,025.00	364,675.0	72%
210402	Тээвэр, шатахуун	18,447,900.0	15,879,842.00	2,568,058.0	86%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	400,000.0	400,000.00	-	100%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.0	120,000.00	-	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,941,000.0	1,538,200.00	402,800.0	79%
2105	Нормативт зардал	29,580,300.0	22,318,636.00	7,261,664.0	75%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,480,300.0	17,974,216.00	5,506,084.0	77%
210502	Хоол, хүнс	4,300,000.0	4,207,620.00	92,380.0	98%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.0	136,800.00	1,663,200.0	8%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.0	4,500,000.00	-	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.0	2,500,000.00	-	100%
210604	Урсгал засвар	2,000,000.0	2,000,000.00	-	100%
2107	Томилолт, зочны зардал	184,000.0	184,000.00	-	100%
210702	Дотоод албан томилолт	184,000.0	184,000.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,300,400.0	1,293,360.00	7,040.0	99%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	347,500.0	347,500.00	-	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.0	450,000.00	-	100%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	102,900.0	102,860.00	40.0	100%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	400,000.0	393,000.00	7,000.0	98%

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,185,200.0	1,185,200.00	-	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,185,200.0	1,185,200.00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600,000.00	600,000.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.0	600,000.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.0	600,000.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	323,443,800.0	312,746,016.00	10,697,784.0	97%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	298,187,200.0	298,187,200.00	-	100%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	298,187,200.0	298,187,200.00	-	100%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,740,000.0	13,715,466.00	24,534.0	100%
132001	Орон нутгийн төсвөөс	13,740,000.0	13,715,466.00	24,534.0	100%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	500,000.00	(500,000.0)	#DIV/0!
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	500,000.00	(500,000.0)	#DIV/0!
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,516,600.0	343,350.00	11,173,250.0	3%
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,516,600.0	343,350.00	11,173,250.0	3%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	8,783.00	8,783.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0	100%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17.00	17.00	0	100%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	0	100%
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	0	100%
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	0	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	28,864,953.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	28,864,953.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	7,864,953.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	4,781,000.00
210104	Урамшуулал		4,781,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	568,585.00
210201	Тэтгэврийн даатгал		454,385.00
210202	Тэтгэмжийн даатгал		35,810.00

210203	ҮОМШӨ-ний даатгал		28,648.00
210204	Ажилгүйдлийн даатгал		4,522.00
210205	Эрүүл мэндийн даатгал		45,220.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	800,311.00
210401	Бичиг хэрэг		50,000.00
210402	Тээвэр, шатахуун		194,896.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		555,415.00
2105	Нормативт зардал	-	1,380,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,380,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	335,057.00
210702	Дотоод албан томилолт		335,057.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	21,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	21,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		21,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	30,282,453.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	30,282,453.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	21,529,953.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	8,752,500.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,417,500.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчдэд ээлтэй сэтгэлд хүрсэн эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламжийг жигд хүртээмжтэй хүргэх чиг үүрэгтэй Баянтоорой тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 163.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24.2 хувиар буюу 84.4 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материалын данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 32.4 сая төгрөг болж 6.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 74.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүй 52.7 сая төгрөгийн эм боох материал, хангамжийн материал хүлээн авч, үйл ажиллагаандаа 120.9 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 325.2 сая төгрөг болж 121.3 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 21.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 414.2 сая төгрөг болж 66.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 52.4 хувиар буюу 166.7 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого, нэмэлт санхүүжилтийн орлого өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 29.4 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 359.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 34.9 сая төгрөгөөр бууруулж, 323.3 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс их байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 323.4 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 298.2 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 13.7 сая төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 0.3 сая төгрөгийн санхүүжилт авч, байгууллагын үйл ажиллагаанаас 0.5 сая төгрөгийн орлого олж, урсгал үйл ажиллагаанд 312.7 сая төгрөгийг зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 312.7 сая төгрөг буюу 97 хувьтай байгаа нь хангамж, бараа материалын зардлыг 3.3 сая төгрөгөөр, нормативт зардлыг 7.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас 21.5 сая төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 8.7 сая төгрөгийн санхүүжилт авч, 28.8 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 1.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын и-баримтыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 169 мэдээллээс 162 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, 7 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 4.7 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг дутуу шивүүлснийг аудитын явцад залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.7 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 5.0 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 23.6 сая төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулсан байна. "Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө" гүйцэтгэлийн аудитаар 29.5 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 5 зөвлөмж хүргүүлсэн, шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар эд хөрөнгийн тооллого, эм, боох материалын үлдэгдэл эмийн сангийн тайлантай нэр төрөл, нэг бүрийн үнэ, тоо ширхгээрээ таарч байгаа эсэхийг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 17.3 сая төгрөгийн алдааг залруулж, 5.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалын тодруулга тайланг 1.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 9.0 сая төгрөгийн дансны ангиллыг буруу тайлагнасныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч

санхүүгийн тайланд залруулав. Нэмэлт санхүүжилтийн төсвийн хэлбэлзэл 1.9 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг аймгийн Төрийн санд хандаж засварлуулахаар тохиролцов. Зардлыг түүвэрлэн үзэхэд 4.7 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайланд нэгээс дээш жилийн насжилттай 4.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй, барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 0.4 сая төгрөгийн илүү, 0.5 сая төгрөгийн дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Эм боох материалын үлдэгдлээс 10 нэр төрлийн эмийг сонгон тоо хэмжээ, нэг бүрийн үнээр нь тулгахад 2 нэр төрлийн эм нярвын тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасныг зөрчсөн, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн дараах зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд шинэчлэгдэж батлагдсан анхан шатны маягтыг ашиглахгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан НББ-ийн анхан шатны маягтыг ашиглах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төв	6	23.1	2	17.3	0	0	3	5.8	1	0